

## РЕДАКЦИЙН ҮГ

“Монголын Хүн Ам ба Хөгжил” Нийгэмлэгээс эрхлэн гаргадаг “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 6 дахь дугаар хэвлэгдэн гарлаа.

Тус сэтгүүл нь Монголын хүн амын судалгааны салбарт тулгамдаж байгаа болон бусад өргөн хүрээний асуудлаар эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээл, тэмдэглэл, судалгааны ажлууд /цаашид бүтээл гэх/-ыг хэвлэн нийтэлж олны хүртээл болгодог билээ.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт ирүүлсэн бүтээлүүдийг судалгааны зорилго, агуулга зэргийг нь үндэслэн “Судалгаа”, “Сургалт”, “Үзэл бодол” гэсэн гурван хэсэг болгож нийтэлсэн бөгөөд бүтээл тус бүрийн товч агуулга тухайн бүтээлийн эхэн хэсэгт бичигдсэн байгаа нь та бүхний сонирхолд нийцнэ гэдэгт найдаж байна.

Уншигч та манай сэтгүүлд өөрийн эрдэм шинжилгээний бүтээлүүдээ хэвлэн нийтлүүлэхийн зэрэгцээ сэтгүүлийн талаарх өөрийн санал бодлоо ирүүлбэл бид гүнээ талархах болно.

Редакцийн Зөвлөл  
2002 оны 8 дугаар сар